



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Өргөө амаржих газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код:НТАГ-2021/548/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2021 он

Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК-ийн

Ерөнхий захирал: Д.Түмэнжаргал

Утас: 70005329

Цахим хаяг: mbr.audit.llc@gmail.com

Аудитын менежер: Д.Нямдорж

Утас: 70005329

Цахим хаяг: mbr.audit.llc@gmail.com

Ахлах аудитор:Н.Алтанзул

Утас: 70005329

Цахим хаяг: mbr.audit.llc@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАГ	Нийслэлийн Өргөө амаржих газар
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМД	Эрүүл мэндийн даатгал

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	14
3. Аудитын тайлан	15
3.1. Ерөнхий зүйл	15
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	15
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	15
3.4. Материаллаг байдал.....	16
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	18
3.7. Шилэн дансны мэдээлэл	19
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
3.9. Аудитын илрүүлэлт	19
Залруулсан алдаа.....	19
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	19
Аудитын зөвлөмж.....	19
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	20
4. Менежментийн захидал	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	23



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2021.07.25 № 437
танай _____-ны № _____-г

НИЙСЛЭЛИЙН ӨРГӨӨ АМАРЖИХ
ГАЗРЫН ДАРГА, ТӨСВИЙН
ШУУД ЗАХИРАГЧ Ж.ЭНХЦЭЦЭГ
ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Өргөө амаржих газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс Нийслэлийн Өргөө амаржих газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 53 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Тайлант онд шатахуун, сэлбэг худалдаж авахаар 6,040.7 мянган төгрөгийг шилжүүлж авлага үүсгэсэн, цалингаас суутгасан 133,788.5 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг төсөвт төвлөрүүлэлгүй өр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  М.ЭРДЭНЭЖАРГАЛ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	591,142,883.79	748,017,943.81
33	АВЛАГА	493,000.00	9,509,786.00
335	Бусад авлага	493,000.00	9,509,786.00
3351	Байгууллагаас авах авлага	493,000.00	9,509,786.00
35	БАРАА МАТЕРИАЛ	590,649,883.79	738,508,157.81
351	Түүхий эд материал	62,721,839.62	218,020,082.66
35130	Эм боох материал	62,721,839.62	218,020,082.66
354	Хангамжийн материал	527,928,044.17	520,488,075.15
35410	Бичиг хэргийн материал	2,365,125.00	3,926,571.00
35420	Аж ахуйн материал	3,139,581.00	9,399,674.00
35430	Сэлбэг хэрэгсэл	17,264,170.00	16,504,700.00
35440	Түлш шатах тослох материал	249,038.60	186,977.00
35450	Барилгын засварын материал		273,460.00
35470	Бусад хангамжийн материал	504,910,129.57	490,196,693.15
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	20,595,887,241.56	20,156,465,441.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	20,595,887,241.56	20,156,465,441.10
392	Биет хөрөнгө	20,151,466,626.56	19,712,060,951.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	18,248,710,256.30	18,272,810,256.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	(538,774,845.12)	(809,253,436.74)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	103,300,000.00	103,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(67,716,666.00)	(72,799,999.92)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	7,148,680,967.47	7,493,730,328.43
39206	Хуримтлагдсан элэгдэл	(4,887,317,011.73)	(5,417,740,943.27)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	487,416,747.09	510,449,649.09
39208	Хуримтлагдсан элэгдэл	(366,100,908.89)	(391,520,723.75)
39213	Түүх соёлын дурсгалт зүйлс	3,000,000.00	3,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,145,329.00	15,145,329.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,514,532.96)	(2,271,799.44)
39217	Ном	6,637,291.40	7,212,291.40
393	Биет бус хөрөнгө	444,420,615.00	444,404,490.00
39301	Програм хангамж	2,021,500.00	2,021,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,951,625.00)	(1,967,750.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	444,350,740.00	444,350,740.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	21,187,030,125.35	20,904,483,384.91
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	116,183,920.00	162,060,897.00
	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	116,183,920.00	162,060,897.00
413	Өглөг	67,033,040.00	133,788,528.00
4131	Ажиллагчидтай холбогдсон өглөг		133,788,528.00
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	67,033,040.00	
4136	Бусад өглөг	49,150,880.00	28,272,369.00
41361	Байгууллагад төлөх өглөг	49,150,880.00	28,272,369.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	21,070,846,204.69	20,742,422,487.92
51	Засгийн газрын хувь оролцоо	21,070,846,204.69	20,742,422,487.92
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,619,067,752.19	5,619,067,752.19
51101	Өмч: - төрийн	5,619,067,752.19	5,619,067,752.19
512	Хуримтлагдсан үр дүн	6,591,389,725.95	6,262,966,009.18
51210	Өмнөх үеийн үр дүн	6,591,389,725.95	6,591,389,725.95
51220	Тайлант үеийн үр дүн		(328,423,716.77)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,860,388,726.55	8,860,388,726.55
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	21,187,030,124.69	20,904,483,384.92

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	11,154,584,886.87	13,203,971,570.45
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,189,308,505.95	1,404,126,162.45
120	Нийтлэг татварын бус орлого	660,518,660.50	707,555,461.95
12004	Төсөв байгууллагын өөрийн орлого	660,518,660.50	707,555,461.95
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	494,501,638.00	479,903,566.25
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,525,571.00	74,293,128.80
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	115,491,451.50	153,358,766.90
	Тусламжийн орлого	528,789,845.45	696,570,700.50
122001	Хандтв тусламж/дотоод/	528,789,845.45	696,570,700.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,965,276,380.92	11,799,845,408.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,716,917,000.00	10,246,728,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,716,917,000.00	10,246,728,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	54,529,270.00	28,779,294.00
131101	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,000,000.00	21,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	4,500,000.00	3,156,434.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	48,029,270.00	4,622,860.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс	1,193,830,110.92	1,524,337,914.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас	1,193,830,110.92	1,524,337,914.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	12,018,027,306.76	13,532,395,287.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,018,027,306.76	13,532,395,287.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,986,040,850.25	13,511,532,958.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,410,980,586.18	7,701,411,457.99
210101	Үндсэн цалин	5,587,635,158.18	6,725,566,893.99
210102	Нэмэгдэл	473,100,000.00	464,422,013.00
210104	Урамшуулал	350,245,428.00	511,422,551.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	817,436,378.35	988,013,599.37
210201	Тэтгэврийн даатгал	564,267,216.35	683,629,992.37
210202	Тэтгэмжийн даатгал	66,384,379.00	80,421,048.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	51,279,662.00	61,843,721.00
210204	Ажилгүйдлийн даатгал	12,240,345.00	14,647,464.00
210205	Эрүүл мэндийн даатгал	123,264,776.00	147,471,374.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	411,332,184.39	425,487,035.00
210301	Гэрэл, цахилгаан	181,234,980.00	192,137,316.00
210302	Түлш, халаалт	99,323,688.39	102,372,266.00
210303	Цэвэр, бохир ус	130,773,516.00	130,977,453.00
2104	Хангамж, бараа материалын зардал	216,843,835.41	324,407,012.01
210401	Бичиг хэргийн материал	20,778,500.00	17,675,705.50
210402	Тээвэр, шатахууны зардал	9,275,033.52	7,822,955.59
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	10,399,199.14	10,904,507.42
210404	Хог хаягдал устгах, цэвэрлэх	133,217,854.80	136,016,242.00
210405	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс		412,000.00
210406	Бараа материал актасны зардал	43,173,247.95	151,575,601.50
2105	Норматив зардал	2,578,133,549.21	2,764,860,574.22
210501	Эм	2,165,533,549.21	2,374,961,074.22
210502	Хоол	412,600,000.00	389,899,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	60,239,300.00	39,005,440.00
210604	Урсгал засвар	60,239,300.00	39,005,440.00

**НИЙСЛЭЛИЙН ӨРГӨӨ АМАРЖИХ ГАЗРЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	78,794,199.00	95,344,544.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,644,000.00	53,566,910.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,550,000.00	8,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	289,332.00	429,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	240,000.00	221,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	50,500.00	66,000.00
210806	Газрын төлбөр	2,879,520.00	2,879,500.00
210807	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	677,642.00	939,600.00
210808	Улсын мэдээллийн маягтын зардал	25,463,205.00	29,242,134.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,412,280,817.71	1,173,003,296.36
	Бараа үйлчилгээний бусад зардал	320,000.00	11,884,496.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,966,400.00	3,038,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,407,994,417.71	1,158,080,100.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,986,456.51	20,862,328.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,734,841.00	9,311,937.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	9,734,841.00	9,311,937.00
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,251,615.51	11,550,391.27
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,251,615.51	11,550,391.27
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(863,442,419.89)	(328,423,716.77)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(863,442,419.89)	(328,423,716.77)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	10,509,853,589.92	12,352,107,323.05
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	544,577,209.00	552,261,915.05
120	Нийтлэг татварын бус орлого	544,577,209.00	552,261,915.05
	Төсөвт байгууллагын өөрийн орлого	544,577,209.00	552,261,915.05
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	494,501,638.00	479,903,566.25
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,075,571.00	72,358,348.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,965,276,380.92	11,799,845,408.00
	Улсын төвлөрсөн төсвөөс	8,716,917,000.00	10,246,728,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,716,917,000.00	10,246,728,200.00
121	Нэмэлт санхүүжилтийн орлого	54,529,270.00	28,779,294.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	2,000,000.00	21,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	4,500,000.00	3,156,434.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	48,029,270.00	4,622,860.00
	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,193,830,110.92	1,524,337,914.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,193,830,110.92	1,524,337,914.00
	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	10,497,178,589.92	12,330,019,723.05
	УРСГАЛ ЗАРДАЛ	10,497,178,589.92	12,330,019,723.05
	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,465,192,133.41	12,309,157,394.78
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	6,356,159,122.95	7,567,622,929.99
210101	Үндсэн цалин	3,895,437,122.95	4,028,000,841.95
210102	Нэмэгдэл	1,545,059,200.00	2,372,788,076.89
210103	Унаа хоолны хөнгөлөлт	562,485,000.00	562,797,012.00
210104	Үр дүнгийн урамшуулал	353,177,800.00	604,036,999.15
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	872,257,841.58	988,013,599.37
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	619,088,679.58	683,629,992.37
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	66,384,379.00	80,421,048.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	51,279,662.00	61,843,721.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	12,240,345.00	14,647,464.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	123,264,776.00	147,471,374.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	411,332,184.39	425,487,035.00
210301	Гэрэл цахилгааны зардал	181,234,980.00	192,137,316.00
210302	Түлш, халаалтын зардал	99,323,688.39	102,372,266.00
210303	Цэвэр, бохир усны зардал	130,773,516.00	130,977,453.00
2104	Хангамж, бараа материалын зардал	176,578,680.54	186,979,728.42
210401	Бичиг хэрэг	13,190,935.00	14,388,410.50
210402	Тээвэр, шатахуун	9,435,945.00	10,499,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,399,199.14	10,904,507.42
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	134,623,578.40	142,276,335.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,929,023.00	8,911,375.50
2105	Нормативт зардал	2,260,742,789.95	2,716,868,890.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,820,314,689.95	2,208,908,371.00
210502	Хоол, хүнс	366,037,500.00	434,825,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	74,390,600.00	73,135,119.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,609,400.00	33,182,850.00

**НИЙСЛЭЛИЙН ӨРГӨӨ АМАРЖИХ ГАЗРЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

210603	Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл	1,181,500.00	4,986,450.00
210604	Урсгал засвар	18,427,900.00	28,196,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	115,512,594.00	99,416,085.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	72,680,000.00	53,566,910.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,550,000.00	8,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	289,332.00	429,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	240,000.00	221,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,500.00	66,000.00
210807	Газрын төлбөр	2,879,520.00	2,879,500.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	677,642.00	939,600.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	31,145,600.00	33,313,675.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	252,999,520.00	291,586,277.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	249,033,120.00	287,692,577.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	3,966,400.00	3,893,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,986,456.51	20,862,328.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,734,841.00	9,311,937.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	9,734,841.00	9,311,937.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,251,615.51	11,550,391.27
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,251,615.51	11,550,391.27
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	12,675,000.00	22,087,600.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	12,675,000.00	22,087,600.00
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,675,000.00	22,087,600.00
	Дотоод эх үүсвэрээр	12,675,000.00	22,087,600.00
	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,675,000.00	22,087,600.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(12,675,000.00)	(22,087,600.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	(0.00)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	5,619,067,752.19	8,860,547,294.08	7,454,673,578.31	21,934,288,624.58
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	158,567.53	158,567.53
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,619,067,752.19	8,860,547,294.08	7,454,832,145.84	21,934,447,192.11
C07	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	(863,442,419.89)	(863,442,419.89)
C08	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	5,619,067,752.19	8,860,388,726.55	6,591,389,725.95	21,070,846,204.69
D01	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	5,619,067,752.19	8,860,388,726.55	6,591,389,725.95	21,070,846,204.69
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,619,067,752.19	8,860,388,726.55	6,591,389,725.95	21,070,846,204.69
D08	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	(328,423,716.77)	(328,423,716.77)
D09	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	5,619,067,752.19	8,860,388,726.55	6,262,966,009.18	20,742,422,487.92

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,800,415,600.00	12,311,859,843.78	488,555,756.22	96.2
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	12,800,415,600.00	12,311,859,843.78	488,555,756.22	96.2
210	Бараа, үйлчилгээний зардал	12,790,675,600.00	12,302,547,906.78	488,127,693.22	96.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,665,961,300.00	7,566,600,980.99	99,360,319.01	98.7
210101	Үндсэн цалин	4,026,913,200.00	4,028,000,841.95	(1,087,641.95)	100.0
210102	Нэмэгдэл	2,472,526,100.00	2,372,078,139.89	100,447,960.11	95.9
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	562,485,000.00	562,485,000.00		100.0
210104	Урамшуулал	604,037,000.00	604,036,999.15	0.85	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,022,437,900.00	987,885,856.37	34,552,043.63	96.6
210201	Тэтгэврийн даатгал	730,604,400.00	683,502,249.37	47,102,150.63	93.6
210202	Тэтгэмжийн даатгал	72,958,400.00	80,421,048.00	(7,462,648.00)	110.2
210203	ҮОМШӨ ний даатгал	58,366,700.00	61,843,721.00	(3,477,021.00)	106.0
210204	Ажилгүйдлийн даатгал	14,591,700.00	14,647,464.00	(55,764.00)	100.4
210205	Эрүүл мэндийн даатгал	145,916,700.00	147,471,374.00	(1,554,674.00)	101.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	425,495,700.00	425,487,035.00	8,665.00	100.0
210301	Гэрэл цахилгаан	192,272,900.00	192,137,316.00	135,584.00	99.9
210302	Түлш, халаалт	102,245,300.00	102,372,266.00	(126,966.00)	100.1
210303	Цэвэр, бохир ус	130,977,500.00	130,977,453.00	47.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	187,082,700.00	186,979,728.42	102,971.58	99.9
210401	Бичиг хэрэг	14,391,000.00	14,388,410.50	2,589.50	100.0
210402	Тээвэр (шатахуун)	10,500,000.00	10,499,100.00	900.00	100.0
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	11,057,500.00	10,904,507.42	152,992.58	98.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	142,200,900.00	142,276,335.00	(75,435.00)	100.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	8,933,300.00	8,911,375.50	21,924.50	99.8
2105	Нормативт зардал	2,722,314,300.00	2,716,868,890.00	5,445,410.00	99.8
210501	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	2,209,028,200.00	2,208,908,371.00	119,829.00	100.0
210502	Хоол, хүнс	440,150,900.00	434,825,400.00	5,325,500.00	98.8
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	73,135,200.00	73,135,119.00	81.00	100.0
2106	Эд хогшил худалдан авах	45,571,400.00	45,502,550.00	68,850.00	99.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,375,000.00	12,319,700.00	55,300.00	99.6
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	5,000,000.00	4,986,450.00	13,550.00	99.7
210604	Урсгал засвар	28,196,400.00	28,196,400.00	-	100.0

**НИЙСЛЭЛИЙН ӨРГӨӨ АМАРЖИХ ГАЗРЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	100,000,100.00	99,416,085.00	584,015.00	99.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,568,500.00	53,566,910.00	1,590.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	8,000,000.00	8,000,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	495,000.00	429,300.00	65,700.00	86.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	240,000.00	221,100.00	18,900.00	92.1
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	120,000.00	66,000.00	54,000.00	55.0
210807	Газрын төлбөр	2,879,500.00	2,879,500.00	-	100.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,051,500.00	939,600.00	111,900.00	89.4
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	33,645,600.00	33,313,675.00	331,925.00	99.0
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	621,812,200.00	273,806,781.00	348,005,419.00	44.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	617,545,800.00	269,563,081.00	347,982,719.00	43.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,266,400.00	4,243,700.00	22,700.00	99.5
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,740,000.00	9,311,937.00	428,063.00	95.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,740,000.00	9,311,937.00	428,063.00	95.6
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	9,740,000.00	9,311,937.00	428,063.00	95.6
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,800,415,600.00	12,311,859,843.78	488,555,756.22	96.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,246,728,200.00	10,235,260,014.73	11,468,185.27	99.9
131001	Улсын төсвөөс санхүүжих	10,246,728,200.00	10,235,260,014.73	11,468,185.27	99.9
1340	НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,989,411,100.00	1,524,337,914.00	465,073,186.00	76.6
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,989,411,100.00	1,524,337,914.00	465,073,186.00	76.6
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	564,276,300.00	552,261,915.05	12,014,384.95	97.9
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	516,187,100.00	479,903,566.25	36,283,533.75	93.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	48,089,200.00	72,358,348.80	(24,269,148.80)	150.5
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	487	487		100.0
620001	Удирдах ажилтан	7	7		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	344	344		100.0
620003	Үйлчлэх ажилтан	136	136		100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	28,697,088.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	28,697,088.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	28,697,088.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,021,949.00
210102	Нэмэгдэл	709,937.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	312,012.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	127,743.00
210201	Тэтгэврийн даатгал	127,743.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,547,396.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,547,396.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	28,697,088.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,697,088.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	21,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,155,112.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,541,976.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Өргөө амаржих газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга Ж.Энхцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагад авлага, өр төлбөр үүсгэхгүй төсвийг үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай зарцуулж байх, бараа материал үндсэн хөрөнгийн ангиллыг үнэн зөв бүртгэж бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-наас 2020 оны 02 дугаар сарын 25-ны хооронд “Монголиан бизнес рейтинг аудит” ХХК-ийн ерөнхий захирал Д.Түмэнжаргал хянан удирдан, Чанарын хяналтын менежер Н.Нямдорж анхан шатны хяналт хэрэгжүүлэн, нар ахлах аудитор Н.Алтанзул, туслах аудитор Г.Буянбадрах нар хариуцаж хэрэгжүүлэв.

Нийслэлийн Өргөө амаржих газар нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Монголиан бизнес рейтинг аудит” ХХК-д 2021 оны 01 сарын 20-ны өдрийн 19 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Нийслэлийн Өргөө амаржих газар нь “Нотолгоонд суурилсан нөхөн үржихүйн эрүүл мэндийн төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг стандартын дагуу хүртээмжтэй чанартай, сэтгэл ханамжтай хүргэж эсэн мэнд амаржуулах үйл явцыг олон улсын жишигт хүргэх” гэсэн эрхэм зорилготой ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

НӨАГ нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус амаржих газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

НӨАГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 12,018,027.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 120,018.0 мянган төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас дахин тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын хувь хэмжээг өөрчлөөгүй бөгөөд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 13,532,394.3 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 135,323.9 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Нийслэлийн Өргөө амаржих газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 282,546.7 мянган төгрөгөөр буюу 9.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	493.0	9,509.8	9,016.8
Бараа материал	590,649.9	738,508.2	147,858.3
Үндсэн хөрөнгө	20,595,887.2	20,156,465.4	(439,421.8)
Нийт хөрөнгө	21,187,030.1	20,904,483.4	(282,546.7)
Нийт өр төлбөрийн дүн	116,183.9	162,060.9	45,877.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	21,070,846.2	20,742,422.5	(328,423.7)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	21,187,030.1	20,904,483.4	(282,546.7)

Оны эхэнд 493.0 мянган төгрөгийн байгууллагаас авах авлагатай байсан бөгөөд оны эцэст 9,509.8 мянган төгрөгийн авлагатай болж 9,016.8 мянган төгрөгөөр өссөн нь түрээслэгч түрээсийн төлбөрөө төлөөгүй болон шатахуун, сэлбэгийн зардлыг урьдчилан шилжүүлснээс шалтгаалсан байна. Үүнд:

Хүснэгт 2. Авлагын үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Харилцагч байгууллага	Авлагын утга	Үлдэгдэл		Өссөн/+, буурсан/-
		2019.12.31	2020.12.31	
МӨАУМ-үүдийн холбоо	Байрны түрээсийн төлбөр	493.0		- 493.0
ТЭХНХ ХХК	Байрны түрээс, цахилгааны төлбөр		2,384.8	2,384.8
Петро стар ХХК	Бензин		2,738.2	2,738.2
Си Ай Ти ХХК	Сэлбэг		3,302.5	3,302.5
Цус сэлбэлт судлалын үндэсний төв	Цус цусан бүтээгдэхүүн		1,084.3	1,084.3
Нийт дүн		493.0	9,509.8	9,016.8

Бараа материалын дансны үлдэгдэл 738,508.2 мянган төгрөг болж 147,858.3 мянган төгрөгөөр өссөн нь эмийн үлдэгдэл 3.5 дахин өссөн нь нөлөөлжээ.

Тус байгууллага тооллогоор илэрсэн шаардлага хангахгүй, эдэлгээний хугацаа дуусаж, цаашид ашиглах боломжгүй болсон 151,575.6 мянган төгрөгийн эм, эмнэлгийн тусламж үйлчилгээний хөрөнгийг /бараа материал/ шийдвэр гарган устгасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 20,156,465.4 мянган төгрөг болж 439,421.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд тооцсон 1,158,080.1 мянган төгрөгийн элэгдлийн зардал нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 22,087.6 мянган төгрөг, хандив, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 696,570.7 мянган төгрөгийн барилга, тоног төхөөрөмж, тавилга, номын хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд Нийслэлийн өмч ашиглалт, удирдлагын газрын 2020 оны 4 дүгээр сарын 06-ны А/110 тоот албан бичиг, НӨАГ-ын даргын 2020 оны 4 дүгээр 16-ны А/53 дугаар тушаалыг үндэслэн 53 нэр төрлийн 70 ширхэг 325,901.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлээс хасаж Нийслэлийн өмч ашиглалт, удирдлагын газарт хүргүүлсэн байна.

Нийт өр төлбөрийн дүн өмнөх оноос 45,877.0 мянган төгрөгөөр өссөн байна. Хэдийгээр оны эхний өр төлбөрийн үлдэгдэл буурсан боловч тайлант онд цалингаас суутгасан 133,788.5 мянган төгрөгийн НДШ-ийг төсөвт төлөөгүйгээс өр төлбөр үүссэн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 1,529,811.2 мянган төгрөгөөр, хандив тусламжийн орлого 19,000.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 1,514,368.0 мянган төгрөгөөр буюу 12.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, нэмэгдэл, НДШ-ийн зардлууд байгаа нь Засгийн газрын 2019-2020 оны холбогдох тогтоолуудаар эмч, ажилтны цалингийн зэрэглэл, шатлал нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Тайлант онд 328,423.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан ба өмнөх оноос алдагдал 535,018.7 мянган төгрөгөөр буурсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 15,832,363.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 15,832,363.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 3,031,948.3 мянган төгрөгөөр бууруулж 12,800,415.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 12,800,415.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 10,246,728.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 1,989,411.1 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 564,276.3 мянган төгрөгийг өөрийн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвийн санхүүжилтээр 10,246,728.2 мянга, Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,524,337.9 мянга, өөрийн орлогоор 552,261.9 мянган төгрөгийг оруулж нийт 12,323,328.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэн, урсгал үйл ажиллагаанд 12,311,859.8 мянган төгрөгийг зарцуулж 11,468.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 12,311,859.8 мянган төгрөг буюу 96.2 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 99,360.3 мянга, НДШ-ийн зардлыг 34,552.0 мянга, нормативт зардлыг 5,445.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Төсвийг дутуу зарцуулсан гэж тайлагнасан хэдий ч ажилтны цалин, нэмэгдлээс суутгасан 133,788.5 мянган төгрөгийн НДШ-ийг төсөвт төлөөгүй өр үүсгэсэн байгаа нь батлагдсан цалингийн зардлыг хэтрүүлэн зарцуулсан байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр арга хэмжээний үзүүлэлт (мянган төгрөгөөр)

№	ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71602-Эмнэлгийн тусламж үйлчилгээ	12,800,415.6	12,311,859.8	488,555.8	96.2
1.1	80101-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал дэмжлэг	12,121,619.2	11,981,475.2	140,144.00	98.8
1.2	80219-Харуул, хамгаалалтын зардал	51,510.6	51,509.6	1.0	100.0
1.3	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, тусламж	9,740.0	9,311.9	428.1	95.6
1.4	81601-Өндөр өртөгтэй мэс заслын зардал	617,545.8	269,563.1	347,982.7	43.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар хандив, тусламжийн орлого 21,000.0 мянга, Нийслэлийн эрүүл мэндийн газраас 3,156.4 мянга, түрээсийн орлого 4,622.8 мянга, нийт 28,779.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалингийн нэмэгдэлд 709.9 мянга, унаа хооны хөнгөлөлтөд 312.0 мянга, НДШ-д 127.7 мянга, хөрөнгө болон засвар үйлчилгээнд 27,547.4 мянга, нийт 28,697.0 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 82.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 557 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн и-баримт буюу цахим төлбөрийн баримтын системд анхан шатны иж бүрдэл дутуу, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах, Нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийн талаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажилласан байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 428,369.4 мянган төгрөгийн зөрчил илэрснийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитын хугацаанд залруулга хийгдээгүй.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Зөвлөмж өгөхөөс бусад асуудал гараагүй болно.

Аудитын зөвлөмж

Аудитаар нийт 428,36.4 мянган төгрөгийн зөрчил илэрснийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаатай холбоотой аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллан нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулах, хөрөнгийн биет тооллого хийх, гэх мэт ажилбарууд хийгдээгүйг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

Тухайлбал, эм, боох материалын нөөц тайлант оны эцэст 3.5 дахин өссөн нь анхаарал татаж байгаа бөгөөд тус эмнэлэг дээр гарсан хөл хорионы улмаас биет тооллого хийх, нягтлан шалгах боломжгүй байсан тул дараагийн аудитын анхаарал татахуйц хэсэгт тусгахаар шийдвэрлэсэн.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Авлага, өр төлбөртэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Шатахуун, сэлбэгийн зардалд нийт 6,040.7 мянган төгрөгийг урьдчилж шилжүүлснээс авлагын үлдэгдэлтэй, цалингаас суутгасан НДШ-д 133,788.5 мянган төгрөгийг төсөвт шилжүүлээгүйгээс өр төлбөрийн үлдэгдэлтэй гарсан байна

1.2. Эрсдэл:

Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, төсвийг зохистой удирдаж зарцуулаагүй байх,

1.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтуудыг хэрэгжүүлж ажиллах, төсөв захирагч тухайн жилийн төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, төсвийг зохистой удирдан авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Тайлбар: НӨАГ-аас дээрх зөрчилтэй холбогдуулан дараах тайлбарыг гаргасан.

"Ковид-19 халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, ЭМС-ын "Өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээг хангах" А/516 тоот тушаалын дагуу Эмэгтэйчүүдийн тасагт 30 ор дэлгэн төлөвлөгөө гарган ажиллаж байгаагаас хэвтэн эмчлүүлэгчдийн тоо буурч ЭМД-ын санхүүжилтийн орлого тасарсан. Зардлын эдийн засгийн ангиллаар төсөвлөгдсөн төсөв хүрэлцэхгүй бүлэг дотор нь зохицуулж гаргасан боловч ЭМД-ын санхүүжилтийн орлого тасарч НДШ-д 133.8 сая төгрөгийн өртэй гарсан.

1.5. Аудитын багийн шийдвэр:

Төсөв захирагч тухайн жилийн төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, төсвийг зохистой удирдаж хүлээсэн үүргээ бүрэн биелүүлээгүй, төсөв хэтрүүлж өр, авлага үүсгэсэн нь баримтаар нотлогдож байгаа тул аудиторын мэргэжлийн шийдлийг хэвээр үлдээв.

2. Худалдан авалттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант онд тус байгууллагын 184 харилцагчтай холбоотой 3,448,084.7 мянган төгрөгийн гүйлгээг цахим татварын системд бүртгэгдсэн төлбөрийн баримттай тулган шалгахад 288,540.2 мянган төгрөгийн баримтууд дутуу байна.

2.2. Эрсдэл:

Нягтлан бодогч анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй ажил гүйлгээг данс бүртгэлд тусгаж тайлагнасан байх,

2.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодогч Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 5 “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” заалтуудыг хэрэгжүүлж татварын цахим төлбөрийн баримтгүй ажил гүйлгээ хийхгүй байх, харилцагч байгууллагаас бүрэн гаргуулан авахад хяналт тавьж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн харуу тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн, зөрчлийг арилгаж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Нийслэл дэх төрийн аудитын газарт 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хянасан:

Аудитын хоёрдугаар хэлтсийн дарга
бөгөөд аудитын менежер

Аудитын менежер



З.Мөнхбаяр
С.Гантөгс

Бэлтгэсэн:

“Монголиан бизнес рейтинг аудит” ХХК-ийн

Ерөнхий захирал

Аудитор



МОНГОЛИАН БИЗНЕС
РЕЙТИНГ АУДИТ ХХК
MONGOLIAN
BUSINESS
RATING AUDIT
LLC
УЛААНБААТАР ХОТ
ТТГ0327/0815061

Д.Түмэнжаргал

Н.Алтанзул

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Нийслэлийн Өргөө амаржих газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2021			НТАГ-2021/548/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<i>Нийслэлийн Өргөө амаржих газар</i>		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Өмнөх оноос авлагын үлдэгдэл 19.2 дахин, өр төлбөрийн үлдэгдэл 1.4 дахин өссөн байна. Үүнд шатахуун, сэлбэгийн зардалд нийт 6,040.7 мянган төгрөгийг урьдчилж шилжүүлснээс авлагын үлдэгдэл, НДШ-д 133,788.5 мянган төгрөгийн өглөг үүссэнээс өр төлбөрийн үлдэгдэлд тус тус нөлөөлсөн байна. Энэ нь төсөв захирагч Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.	139,829.2	Зөвлөмж өгөх	Эмнэлгийн дарга, Нягтлан бодогч	Ж.Энхцэцэг Ч.Гангэрэл
2	Тайлант онд тус байгууллагын 184 харилцагчтай холбоотой 3,448,084.7 мянган төгрөгийн гүйлгээг цахим төлбөрийн баримтын системийн баримттай тулган шалгахад 288,540.2 мянган төгрөгөөр дутуу илэрсэн.	288,540.2	Зөвлөмж өгөх	Эмнэлгийн дарга, Нягтлан бодогч	Ж.Энхцэцэг Ч.Гангэрэл
ДҮН		428,369.4			